



ДУНДГОВЬ АЙМАГ  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 4/14

Мандалговь

Г Зориулалтын бус хуванцар савны  
хэрэглээг хориглох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (л), Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 12 дугаар зүйлийн 12.1, Засгийн газрын 2015 оны 496 дугаар тогтоол, 2016 оны 287 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Хүнсний худалдаа, үйлчилгээ, нийтийн хоол, сургууль цэцэрлэг, дотуур байр, айл өрхүүдэд хэрэглэж байгаа хүний эрүүл мэндэд хортой, сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг хориглосугай.

2.Хүнсний савны хэрэглээнд хяналт тавих, иргэд ААНэгж, албан байгууллагад “Зориулалтын бус хуванцар савны” талаар зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулж ажиллахыг Худалдаа үйлчилгээ, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа), Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Б.Нанжид), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга, Улсын байцаагч (Е.Отгонцэцэг), Худалдаа үйлчилгээ, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа), Цагдаагийн хэсгийн байцаагч (Б.Билгүүн), багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

